Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2017 оны ....... дугаар сарын .....-ны
өдрийн.........дугаар тогтоолын хавсралт

## ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

| № | Дүүргийн засаг даргын 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | 2018 онд хүрэх түвшин, үр дүн | Шаардлагатай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая.төг/ | Хариуцах хэлтэс, албад |
|---|---|---|---|---|---|---|
| | **НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ-ӨРХ БҮРД** | | | | | |
| **1** | **1.1 Үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр** | | | | | |
| 1-1 | 1.1.1 Хөнгөн үйлдвэрийн чиглэлээр орчин үеийн шинэ дэвшилтэт техник, технологи нэвтрүүлсэн дүүргийн бүтээн байгуулагчдыг дэмжиж ажиллана. | Орчин үеийн техник технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн дүүргийн үйлдвэрүүдийн судалгааг гаргаж олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна. | Судалгаа шинжилгээний тоо | 1 | 1.0 /хэлтсийн төсөв/ | **ХүХҮХ** |
| **2** | **1.2 Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр** | | | | | |
| 1-2 | 1.2.1 Дүүрэгт жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих борлуулалтын нэгдсэн төвийг байгуулж, "Хан-Уул брэндинг" шинээр бий болгоно. | Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн судалгаа мэдээллийн баазыг баяжуулан, "Хан-Уул брэндинг" өвөрмөц дүр төрх бүхий бүтээгдэхүүн сонгох ажлыг зохион байгуулна. | Сонгон шалгаруулалт хийх давтамж | 2 | 11.5 /хэлтсийн төсөв/ | **ХүХҮХ ЖДҮДТ** |
| 1-3 | | Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд сургалт, зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээ үзүүлэх, судалгаа хийх, үзэсгэлэн яармагт оролцуулан үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | 4.5 /хэлтсийн төсөв/ | **ХүХҮХ ЖДҮДТ** |
| 1-4 | 1.2.2 Орчин үеийн дэвшилтэт технологи бүхий бага, дунд оврын жишиг загвар бүхий үйлдвэр байгуулахыг дэмжинэ. | Дүүргийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж бараа бүтээгдэхүүнийг борлуулах бойжуулах төвийн судалгаа хийнэ. | Үйл ажиллагааны хэрэжилт хувиар | 100% | 1.0 /ЖДҮДТ-ийн төсөв/ | **ЖДҮДТ** |
| 1-5 | 1.2.3 Дүүргийн иргэдийн өрхийн бизнесийг дэмжих зорилго бүхий интернэт худалдааны платформыг бий болгоно. | Дүүргийн ЖДҮДТ-ийн цахим хуудсыг олон нийтэд сурталчлан иргэдийн хандалтыг нэмэгдүүлнэ. | Үйл ажиллагааны хэрэжилт хувиар | 100% | - | **ЖДҮДТ** |
| **3** | **1.3 Хүнс хөдөө аж ахуйн салбарын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр** | | | | | |
| 1-6 | 1.3.2 Дүүргийн газар тариалан эрхлэгчдийг эрсдэлээс хамгаалах үүднээс даатгалд хамруулах чиглэлээр сургалт, мэргэжлийн зөвлөгөөгөөр хангана. | Тариаланчдыг газар тариалангийн даатгалд хамруулах, өрхийн тариаланг нэмэгдүүлэн, хөрс, цаг уурын онцлогт тохирсон тарималыг тариалж, бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлэн борлуулалтыг дэмжин ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | 8.5 /хэлтсийн төсөв/ | **ХүХҮХ** |
| **4** | **1.4 Аялал жуулчлалын чиглэлээр** | | | | | |
| 1-7 | | "Дээлтэй Монгол-2018" арга хэмжээнд зохион байгуулалтыг хангаж оролцоно. | Хамрагдах иргэдийн тоо | 1000-аас доошгүй | 1.5 /хэлтсийн төсөв/ | **НХХ** |

| № | Дүүргийн засаг даргын 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | 2018 онд хүрэх түвшин, үр дүн | Шаардлагатай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая.төг/ | Хариуцах хэлтэс, албад |
|---|---|---|---|---|---|---|
| 1-8 | 1.4.1 Аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор дүүрэгт соёл урлаг, спорт, олон нийтийн арга хэмжээг тогтмол зохион байгуулна. | Дүүргийн хэмжээнд оны шилдгүүдийг шалгаруулж алдаршуулах, иргэдийн шинэ жилийн баярын үйл ажиллагааг нэгдсэн байдлаар зохион байгуулна. | Зохион байгуулах арга хэмжээний тоо | 1 | 2.5 /хэлтсийн төсөв/ | НХХ |
| 1-9 | | Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор дүүрэг дэх түүх, соёлын дурсгалт газрын зурагт танилцуулга хийж иргэдийн мэдлэгийг өргөжүүлнэ. | Зураг авалт, танилцуулга боловсруулах баримт бичгийн явц | 100% | 2.5 /хэлтсийн төсөв/ | ХүХҮХ |
| 1-10 | | Хүүхэд, залуучуудад байгаль орчинд ээлтэй эко аялал зохион байгуулна. | Хамрагдсан сурагчийн тоо | 100% | 2.7 /хэлтсийн төсөв/ | ХүХҮХ |
| 1-11 | | Зочлох үйлчилгээний салбарын ажилтнуудад сургалт зохион байгуулах, олон улсын стандартад нийцсэн өндөр зэрэглэлийн зочид буудлын үйл ажиллагаатай танилцуулах, харилцан туршлага судлах арга хэмжээг зохион байгуулна. | Зохион байгуулсан сургалт, хамрагдсан иргэдийн тоо | 2 сургалт, 100 ажилтан | 2.0 /хэлтсийн төсөв/ | ХүХҮХ |
| 1-12 | 1.4.2 Яармаг, Нисэхийн орчимд иргэдийн амралт чөлөөт цагаа өнгөрөөх, аялал жуулчлалыг нэмэгдүүлэх зорилго бүхий дөрвөн улирлын цэцэрлэгт хүрээлэн байгуулна. | Нисэх, Яармагийн бүсэд амралт, чөлөөт цаг, аялал жуулчлалын зурвас байгуулах суурь судалгаа хийж хөрөнгийн эх үүсвэрийг судалж холбогдох дэд шатны байгууллагад уламжилна. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | | ТГХШХ ГА |
| 5 | 1.5 Төр хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах чиглэлээр | | | | | |
| 1-13 | 1.5.2 Дүүрэгт тулгамдаж буй асуудал /агаар, ус, хөрсний бохирдол, нийтийн тээвэр/-ыг шийдвэрлэхэд гадаад улс, хотуудын туршлагаас судалж, нэвтрүүлнэ. | Дүүргийн өмнө тулгамдаж байгаа агаар,ус,хөрсний бохирдлын асуудлыг шийдвэрлэхэд гадаад улс,хотуудын тэргүүний туршлага,техник,технологийг судлах зорилгоор олон улсын сургалт,семинар,хурал,үзэсгэлэнд оролцож судалсан туршлагыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | - | ТНААХ |
| 6 | 1.6 Дүүргийн орлого санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх чиглэлээр | | | | | |
| 1-14 | 1.6.1 Дүүргийн өмчид байгаа хөрөнгийн ашиглалт, үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлнэ. | Дүүргийн өмчид байгаа хөрөнгийн ашиглалтад хагас болон бүтэн жилийн байдлаар хяналт шинжилгээ хийж холбогдох арга хэмжээг авч ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | - | СТСХ |
| 1-15 | 1.6.2 Иргэдийн ажиллаж амьдрах эрүүл, тохилог, аюулгүй орчинг бүрдүүлэх зорилгоор "Орон нутгийн хөгжлийг дэмжих сан"-ийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, иргэдийн оролцоог хангаж ажиллана. | Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж төсөл арга хэмжээг иргэдийн оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | - | ТГХШХ СТСХ |
| 1-16 | 1.6.3 Орон нутгийн төсвийн орлогын баазыг өргөжүүлэн эх үүсвэрийг нэмэгдүүлж татварт хамрагдалтын төвшинг ахиулна. | Хөндлөнгийн мэдээлэлд үндэслэн татварын мэдээллийн санг баяжуулах,татварын ногдлыг бүрэн хийх замаар татварт хамрагдалтын түвшинг нэмэгдүүлнэ. | Төсвийн орлогын гүйцэтгэл, өссөн хувиар | 3-5% | 16.5 /хэлтсийн төсөв/ | СТСХ ТХ |
| | ХОЁР. ХОТ БАЙГУУЛАЛТ, ДЭД БҮТЭЦ | | | | | |
| 7 | 2.1 Тохилог орчин-тухтай амьдралын үндэс | | | | | |
| 2-1 | 2.1.2 Залуу гэр бүл, зорилтот хэсгийг судалгаанд хамруулж үе шаттайгаар түрээсийн орон сууц болон ипотекийн зээлд хамруулна. | Түрээсийн орон сууц болон ипотекийн зээлд хамрагдах хүсэлтэй зорилтот өрхийн залуу гэр бүлийн судалгаар харьяа хэлтэс албадуудтай хамтран боловсруулж ТОСК, НОСК-д иргэдийн хүсэлтийг уламжилна. | Судалгааны тоо, ажлын явц, хувиар | 1 100% | - | НХХ СТСХ |

| № | Дүүргийн засаг даргын 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | 2018 онд хүрэх түвшин, үр дүн | Шаардлагатай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая.төг/ | Хариуцах хэлтэс, албад |
|---|---|---|---|---|---|---|
| 2-2 | 2.1.3 Ашиглалтын шаардлага хангахгүй байгаа нийтийн зориулалттай орон сууцнуудыг үе шаттайгаар шинэчлэнэ. | Ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууцны судалгааг шинэчлэн гаргаж иргэдийн хүсэлтийг дээд шатны байгууллагуудад уламжилж хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийг эрчимжүүлэх арга хэмжээг авч ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | - | ТГХШХ |
| 2-3 | 2.1.4 Хуучирсан орон сууцнуудыг сайжруулах, дулаалах ажлуудыг оршин суугчдын ойлголцол дэмжлэгт тулгуурлан хийж гүйцэтгэнэ. | Банк санхүүгийн байгууллагуудтай хамтран орон сууцаа дулаалах хүсэлтэй иргэдэд хөнгөлттэй нөхцөлөөр зээл олгуулах талаар хамтран ажиллах эхлэлийг тавина. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | - | ТНААХ |
| **8** | **2.2 Инженерийн шугам сүлжээний хангамжийг сайжруулах чиглэлээр** | | | | | |
| 2-4 | 2.2.1 Гэр хорооллын айл өрхүүдийг бүрэн шаталтат зуухаар иж бүрэн хангаж, халаалтанд шингэрүүлсэн түлш болон хямд цахилгааны эх үүсвэрийг нэмэгдүүлнэ. | Байгальд ээлтэй технологийг нэвтрүүлэх, үзэсгэлэн худалдаа зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | 2.0 /хэлтсийн төсөв/ | ТНААХ |
| 2-5 | 2.2.2 Гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай өрхийг цахилгаан эрчим хүчээр үе шаттай хангана. | Цахилгаангүй болон хүчдэлийн уналттай өрхийн судалгааг 2018 оны байдлаар 1-р улиралд багтаан гаргаж судалгааны дагуу зураг төсөв хийлгэх ажлыг холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна. | Судалгааны тоо | 1 | - | ТНААХ |
| 2-6 | 2.2.3 Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, орон сууц, гэр хорооллын гэрэлтүүлгийг сайжруулж, нэгдсэн удирдлагын системд бүрэн холбоно. | Нэгдсэн удирдлагын системд холбогдох хүсэлтийг дээд шатны байгууллагад уламжлах, гэрэлтүүлэг сайжруулах шаардлагатай байршлын судалгааг гарган нийслэлийн төсвийн хөрөнгөөр гэрэлтүүлэг хийх ажлыг хэсэгчилсэн байдлаар хийж эхлүүлнэ. | Судалгааны тоо, ажлын явц, хувиар | 1<br>100% | - | ТНААХ |
| 2-7 | 2.2.4 Нисэх, Яармагийн гэр хорооллыг дахин төлөвлөлтөөр бие даасан болон төвлөрсөн инженерийн шугам сүлжээтэй болгох ажлыг тууштай үргэлжлүүлнэ. | 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 200-300 айлын дунд гэр хорооллын дэд бүтцийн төвлөрсөн систем /сервис центр/ бүхий төв байгуулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Бие даасан болон төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбогдох хүсэлтэй иргэдийг нэгдсэн зохион байгуулалтад оруулж гарсан санал хүсэлтийг дээд шатны байгууллагад уламжилна. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | 2.0 /хэлтсийн төсөв/ | ТГХШХ |
| 2-8 | 2.2.5 Хороолол дундах зам талбайн ус зайлуулах сувгууд болон үерийн далан хамгаалалтыг шинээр бий болгоно. | Үер усны аюулд өртөх магадлалтай газрын байршлын судалгааг гаргаж мэргэжлийн байгууллагад хүргүүлэн үерийн далан барих ажлын зураг төсөв хийлгэх арга хэмжээг авч ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | - | ТНААХ |
| **10** | **2.4 Авто зам шинэчлэлийн чиглэлээр** | | | | | |
| 2-9 | 2.4.1 Дүүргийн замын ачаалал, орон сууц хоорондын зай талбайн байдалд иж бүрэн үнэлгээ хийж, авто замыг хөгжүүлэх шинэчилсэн төлөвлөгөө гаргана. | Шинэчлэн засварлан шаардлагатай болон шинээр байгуулах авто замын судалгааг НАЗГ-тай хамтран гаргана. | Судалгааны тоо | 1 | 1.0 /хэлтсийн төсөв/ | ТНААХ |
| 2-10 | 2.4.2 Ерөнхий төлөвлөгөө, замын сүлжээний зураг төслийн дагуу авто замыг шинээр байгуулна. | Наадамчдын замын уулзвараас Яармагийн автобусны шинэ эцсийн буудал хүртэл хатуу хучилттай авто зам тавих ажлыг эхлүүлнэ. | Ажлын явц, хувиар | 100% | 1.096.3 УТХО | ТНААХ |

| № | Дүүргийн засаг даргын 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | 2018 онд хүрэх түвшин, үр дүн | Шаардлагатай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая.төг/ | Хариуцах хэлтэс, албад |
|---|---|---|---|---|---|---|
| 2-11 | 2.4.4 Дүүрэгт авто зогсоол, хүүхдийн тоглоомын талбайг иж бүрнээр нь шийдвэрлэх замаар орон сууцны гаднах ил зогсоол, машины бөөгнөрлийн асуудлыг шийдэж оршин суугчдын ая тухтай байдлыг хангана. | Шинээр байгуулах шаардлагатай хүүхдийн тоглоомын талбай болон газар доорх авто зогсоолын байршлын судалгааг гаргана. | Зураг төсвийн ажлын явц, хувиар | 100% | - | ГА ТГХШХ |
| | **ГУРАВ. ЭКО ДҮҮРЭГ- НОГООН ХӨГЖИЛ** | | | | | |
| **11** | **3.1 Хүрээлэн буй орчны тогтвортой хөгжлийн чиглэлээр** | | | | | |
| 3-1 | 3.1.1 Арьс ширний үйлдвэрүүдийг дүүргийн нутаг дэвсгэрээс гаргах талаар авч хэрэгжүүлсэн шат дараатай арга хэмжээнүүдийг үргэлжлүүлж, үйлдвэрийн бохирдлыг бүрэн цэвэршүүлэх шинэ технологи нэвтрүүлнэ. | Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан "Арьс шир, ноос ноолуур боловсруулах үйлдвэрүүдийг дүүргийн нутаг дэвсгэрээс шилжүүлэн суурьшуулах ажлын бэлтгэл хангах ажлыг зохион байгуулна. | Ажлын явц, хувиар | 100% | - | ТНААХ |
| 3-2 | 3.1.2 Хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй, дэвшилтэт технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах тогтолцоог бий болгоно. | Хүний эрүүл мэнд, байгаль орчинд хор нөлөөгүй орчин бүрдүүлсэн ногоон аж ахуйн нэгж, сургууль, цэцэрлэг тодруулах арга хэмжээг зохион байгуулж шалгарсан аж ахуйн нэгжүүдийг урамшуулна. | Арга хэмжээний тоо | 1 | 5.0 /хэлтсийн төсөв/ | ТНААХ |
| 3-3 | 3.1.3 Байгаль орчин, эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй үйлдвэрлэл, үйлчилгээ болон байгалийн нөөцийн хууль бус ашиглалт, нөхөн сэргээлтэд тавих хяналтыг сайжруулж хариуцлагыг дээшлүүлнэ. | Дүүргийн 10, 12, 13, 14 дүгээр хороодын нутаг дэвсгэрт элс хайрга дайрга олборлож байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газруудад нөхөн сэргээлт хийлгэж , тухайн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын хэсэг, төлөвлөгөөг гаргаж хуулийн хэрэгжилтийг хангуулж хяналт тавьж ажиллана. | Хяналт шалгалт хийх тоо | 10 | 50.0 /Байгаль хамгаалах, тоосжилтыг бууруулах зардал/ | ТНААХ |
| **12** | **3.2 Орчны бохирдлыг бууруулах чиглэлээр** | | | | | |
| 3-4 | 3.2.1 Дүүргийн суурьшлын бүсийн хөрсний доройтол, бохирдлыг бууруулах төсөл хэрэгжүүлэх, суурь судалгааг оновчтой хийж, олон нийтэд хөрсний бохирдлын талаар ойлголт, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулна. | Дүүргийн суурьшлын бүсийн хөрсний доройтол, бохирдлын судалгаанд үндэслэн хамгийн их бохирдолтой, эрсдэл өндөр хэсгүүдэд ариутгал халдваргүйжүүлэлтийг үе шаттайгаар зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | 36.0 /хэлтсийн төсөв/ | ТНААХ |
| 3-5 | 3.2.2 Агаарын бохирдлыг бууруулах ногоон технологи нэвтрүүлнэ. | Гэр хорооллын айл өрхөд шинэ дэвшилтэт технологийн цахилгаан халаагуур нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ. | Хяналт шалгалт хийх тоо | 130 | 2.0 /хэлтсийн төсөв/ | МХХ ТНААХ |
| 3-6 | 3.2.3 Агаарын бохирдол үүсгэгч гэр хорооллын зуух, авто машины утаа, нам даралтат зуух зэрэг гол эх үүсвэрүүдийг хүний эрүүл мэндэд хортой байдлаар нь эрэмбэлэн тогтоож, эрүүл мэндэд хамгийн их хор хүргэж буй эх үүсвэрт анхаарал хандуулж ажиллана. | Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах газартай хамтран авто машины утааны хэмжилтийг томоохон уулзваруудад хийлгэх төлөвлөгөө боловсруулан агаарын бохирдол үүсгэгч яндангийн тоог цөөрүүлэх арга хэмжээ авч ажиллана. | Ажлын явц, хувиар | 100% | 4.0 /хэлтсийн төсөв/ | ТНААХ |
| **13** | **3.3 Хот тохижилт, ногоон байгууламжийн чиглэлээр** | | | | | |
| 3-7 | 3.3.1 Гэр хорооллын гэрэлтүүлэг, зам талбай, хайс хашааны стандарт, жишгийг шинэчлэн тогтоож мөрдүүлнэ. | Нийслэлийн Захирагчийн ажлын албанаас баталсан стандартын хэрэгжилтийг 16 хорооны нутаг дэвсгэрт хангуулж ажиллана. | Хяналт шалгалт хийх тоо | 3 | - | ТНААХ |

| № | Дүүргийн засаг даргын 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | 2018 онд хүрэх түвшин, үр дүн | Шаардлагатай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая.төг/ | Хариуцах хэлтэс, албад |
|---|---|---|---|---|---|---|
| 3-8 | 3.3.2 Харшлын өвчин үүсгэгч ургамлыг устгах, тоосонцрын дэгдэлтийг бууруулах арга хэмжээ авна. | Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд ургасан зэрлэг ургамлыг устгах, ургамлын өвчин, хортон шавьжтай тэмцэх, ургамлын хөрсийг ариутгах ажлыг зохион байгуулж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. | Хяналт шалгалт хийх тоо | 8 | 2.0 /хэлтсийн төсөв/ | ТНААХ |
| 3-9 | 3.3.3 Дүүргийн хэмжээнд ногоон байгууламжийн хэмжээг 2-3 дахин нэмэгдүүлнэ. | Мод үржүүлэг, суулгац тарих хүсэлтэй иргэд байгууллага, аж ахуйн нэгжүүдийг дэмжиж, дүүргийн шороон хөрс бүхий газрыг зүлэгжүүлнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | 25.0 /хэлтсийн төсөв/ | ТНААХ |
| 3-10 | 3.3.4 Дүүргийн тоосжилтыг бууруулах зорилгоор гудамж талбайг зүлэгжүүлж, хатуу хучилттай болгоно. | Орон сууцны дундах болон нийтийн эзэмшлийн хатуу хучилттай эвдэрсэн талбайг нөхөн сэргээж, засварлана. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | 25.0 /ДТХО/ | ТНААХ<br>ТҮТ<br>ОНӨААТҮГ |
| 3-11 | 3.3.5 Гэр хорооллын зам талбайг цардмалжуулах, шаардлагатай хэсгүүдийг чулуун хучилттай болгох ажлуудыг хороодын иргэдийн бүлэг, бизнес нөхөрлөлүүдээр гүйцэтгүүлнэ. | Хатуу хучилттай болгох боломжтой сул шороон хөрс бүхий газруудын судалгаар гаргаж дүүргийн хэмжээнд хийгдэх нийт ажлын төсвийн тооцоололыг гаргана. | Судалгааны тоо | 1 | - | ТНААХ |
| 3-12 | 3.3.6 Туул, Дунд голын дагуух дүүргийн нутаг дэвсгэрт амралт, үйлчилгээний эко зурвасуудыг байгуулна. | Туул голын дагуу амралт, үйлчилгээний газар байгуулах боломжтой газрын байршлыг тогтоож улс, нийслэлийн төсвийн хөрөнге оруулалт, олон улсын байгууллагын санхүүгийн дэмжлэгээр бүтээн байгуулах ажлыг үе шаттай зохион байгуулна. | Ажлын явц, хувиар | 100% | - | ГА<br>ТНААХ<br>ТГХШХ |
| 3-13 | 3.3.7 Мод тарьсан, ногоон байгууламж бий болгосон иргэд, байгууллагыг урамшуулах тогтолцоог оновчтой зохион байгуулна. | Мод тарьж, ногоон байгууламж бий болгосон иргэд, ААН-ийн судалгаар гаргаж урамшуулах ажлыг зохион байгуулна. | Судалгааны тоо | 1 | 2.0 /хэлтсийн төсөв/ | ТНААХ |
| 3-14 | 3.3.9 Дүүргийн тохижилт, архитектор-дизайн шийдлийг нэгдсэн бодлогоор хангах бүтэц бий болгон хэрэгжүүлж ажиллана. | Нийслэлийн ерөнхий төлөвлөгөө, дүүргийн онцлогтой уялдуулан хот төлөвлөлтийн нэгдсэн загвар, шийдэл гаргах судалгааны ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран хийж, хороодын байрны гадна фасад болон дотор тохижилтыг нэг хэв маягийн өнгө төрхтэй болгоно. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | - | ТГХШХ |
| 3-15 | 3.3.10 Хог хаягдал үүсгэж, гудамж талбай бохирдуулах аливаа үйлдэлд хатуу хяналт тавьж шийдвэрлэж байх үүднээс дүүргийн байгууллага, албан газрууdтай харилцан ойлголцлын гэрээ байгуулж, ахмад залуу үеийнхнээс бүрдсэн эргүүлийн баг ажиллуулан хамтарч ажиллана. | Хог хаягдлыг ангилан ялгах ажлыг төрийн болон төрийн өмчийн сургууль, цэцэрлэгт хэвшүүлж, иргэд, ААНБ-уудад үе шаттайгаар нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ. Хог хаягдлын олон нийтийн байцаагчийг ажиллуулж хяналт тавьж ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | 30.0 /хэлтсийн төсөв/ | ТНААХ<br>ТҮТ<br>ОНӨААТҮГ<br>ТХ<br>ХөХҮХ |
| 3-16 | 3.3.11 Дүүргийн хэмжээн дэх зам талбай, олон нийтийн эзэмшлийн газруудад мөрдөгдөх аюулгүйн зааварчилгаа, тэмдэг тэмдэглэгээг шинэчлэн сайжруулна. | Нийтийн эзэмшлийн зам талбайн эвдэрч, хуучирсан тэмдэг тэмдэглэгээг УБхотын ЗАА-наас баталсан стандартын дагуу шинэчлэн сайжруулна. Сургууль, цэцэрлэг, орон сууцны дунд анхааруулах самбар байрлуулах ажлыг эхлүүлнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | 22.0 НОНХС | ТНААХ |
| | **ДӨРӨВ. АЗ ЖАРГАЛТАЙ АМЬДРАЛ** | | | | | |
| 14 | **4.1 Сургууль цэцэрлэгийн хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх чиглэлээр** | | | | | |

| № | Дүүргийн засаг даргын 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | 2018 онд хүрэх түвшин, үр дүн | Шаардлагатай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая.төг/ | Хариуцах хэлтэс, албад |
|---|---|---|---|---|---|---|
| 4-1 | 4.1.1 Сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр сургуулийн барилгыг өргөтгөх буюу шинээр барьж, сургуулиудыг хоёр ээлжид бүрэн шилжүүлнэ. | 75 дугаар сургуулийг буулгаж барилгажуулах, БУЦС, 52, 114 дүгээр сургуулиудын өргөтгөлийн барилгын ажлыг эхлүүлнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | - | **БХ ТГХШХ** |
| 4-2 | 4.1.2 Цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын түвшинг үе шаттайгаар өсгөнө. | 3-р хороо 46 дугаар цэцэрлэгийн барилгын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулна. | Ашиглалтад орох цэцэрлэгийн тоо | 1 | 863.0 /ДТХО/ | **БХ ТГХШХ** |
| 4-3 | | 4-р ясли, 28 дугаар цэцэрлэгийн барилгыг буулгаж дахин барилгажуулах, 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт шинэ цэцэрлэг барих ажил, 53, 49, 73 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажлыг улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр эхлүүлнэ. | Ажлын явц, хувиар | 100% | - | **БХ ТГХШХ** |
| 4-4 | 4.1.4 Гэр хороололд хүүхдийн тоглоомын талбай, чийрэгжүүлэлтийн талбайг шинээр барьж байгуулна. | Хороолол дунд хүүхдийн тоглоомын талбай, чийрэгжүүлэлтийн талбай байгуулах ажлыг тооцоо судалгаанд үндэслэн холбогдох дээд шатны байгууллагуудад уламжилж эвдэрч гэмтсэн хуучин тоглоомын талбайг сэргээн засварлана. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | 2.0 /хэлтсийн төсөв/ | **ТНААХ НҮА ОНӨААТҮГ** |
| 4-5 | 4.1.5 Авто машины төвлөрөл ачааллыг бууруулах, нийтийн тээврийн соёлтой үйлчилгээг нэвтрүүлэх үүднээс дүүрэгт Сургуулийн автобус, Богино эргэлтэт шуурхай автобус-ыг бий болгож үйлчилгээнд нэвтрүүлнэ. | 10 дугаар сургуулийг сурагчдад зориулсан автобустай болгох асуудлыг БСШУЯ, НБГ-т уламжилна. | Автобусны тоо | 1 | - | **БХ** |
| 4-6 | 4.1.6 Сургуульд "Биеийн тамирын талбай", "Монгол зан заншил, соёлын төв", цэцэрлэгт "Эцэг эхэд зөвлөгөө өгөх төв" байгуулна. | 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт хүүхэд залуучуудад зориулсан хөлбөмбөгийн талбай шинээр байгуулах ажлыг эхлүүлнэ. | Ажлын явц, хувиар | 100% | 350.0 УТХО | **ТГХШХ** |
| 4-7 | 4.1.7 Сургууль, эцэг эх, сурагчдын хооронд мэдээлэл солилцох цахим системийг боловсронгуй болгож, сургалтын үйл ажиллагаа, чанар, ажлын үр дүнг эцэг эхийн оролцоотойгоор үнэлж дүгнэх тогтолцоог боловсруулна. | Эцэг эх, сурагчдын хооронд мэдээлэл солилцох цахим системийг боловсронгуй болгож, сургалтын үйл ажиллагаа, чанар, ажлын үр дүнг эцэг эхийн оролцоотойгоор үнэлж дүгнэх програмыг СӨБ-ын түвшинд хэрэгжүүлнэ. | Програм хангамжийн тоо | 1 | - | **БХ** |
| **15** | **4.2 Эрүүл мэндийн чиглэлээр** | | | | | |
| 4-8 | 4.2.1 Иргэдийг чихрийн шижин, цусны даралт ихсэх, хорт хавдар зэрэг зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгт жилд нэг удаа үнэ төлбөргүй хамруулах, өвчнийг хянах цогц арга хэмжээ хэрэгжүүлнэ. | Хүн амын дунд ХБӨ-ний эрсдэл болон хүндрэлээс сэргийлэх талаар эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтын хувийг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг сайжруулахад чиглэсэн ажлыг зохион байгуулна. (ӨЭМТ-үүдэд аян өрнүүлж дүгнэж, урамшуулах) | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | 5.0 /хэлтсийн төсөв/ | **НХХ** |

| № | Дүүргийн засаг даргын 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | 2018 онд хүрэх түвшин, үр дүн | Шаардлагатай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая.төг/ | Хариуцах хэлтэс, албад |
|---|---|---|---|---|---|---|
| 4-9 | 4.2.2 Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүлжүүлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулж шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. | Дүүргийн ЕБС, цэцэрлэгүүдийн эмч, эцэг эхчүүд, сурагчдын дунд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг үе шаттай явуулах, хяналт тавих, тараах материал болон зурагт хуудас тараах, эрүүл мэндийн үзлэгт хамруулж эрүүлжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | 1.0 /хэлтсийн төсөв/ | **НХХ ЭМТ** |
| 4-10 | 4.2.3 Сүрьеэгийн идэвхтэй эрт илрүүлгийг сайжруулж, өртөмтгий бүлгийн иргэдийн судалгааг гарган урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд жилд 1 удаа оруулж эмчилгээний хамрагдалтыг 10-аас доошгүй хувиар нэмэгдүүлэн өвчлөлийн төвшинг бууруулах арга хэмжээ авч ажиллана. | Эрсдэлт бүлгийн хүн амыг сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлтэнд хамруулж "Сүрьеэгүй Хан-Уул" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | Хамрагдалтын өссөн хувиар | Эрт илрүүлэг 2016 онтой харьцуулахад 30%-иар нэмэгдэнэ | - | **ЭМТ** |
| 4-11 | 4.2.5 Хороодын өрхийн эмнэлгүүдийн үйлчилгээний стандартыг шинэ түвшинд гаргаж, иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэхэд анхаарч материаллаг бааз, хүний нөөцийн ур чадвар, боловсон хүчний орон тоо, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Өрхийн эрүүл мэндийн төвийн үйлчилгээний хүрэлцээ муу хороодод шинээр Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга барих ажлыг ЭМЯ болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна. | Ажлын явц, хувиар | 100% | - | **НХХ** |
| **16** | **4.3 Соёл урлагийн чиглэлээр** | | | | | |
| 4-12 | 4.3.1 Бүх шатны боловсрол, соёлын байгууллагууд болон олон нийтийн сүлжээг ашиглан соёлын боловсрол олгох "Хотын соёл" олон нийтийн аян өрнүүлнэ. | "Аз жаргалтай хотын индекс"-ийн судалгааны аргачлалын талаар сургалт зохион байгуулж хотын соёл боловсрол олгох арга хэмжээг хүүхэд , залуучууд иргэдэд үе шаттай хүргэнэ. Ахлах, дунд, бага ангиудад сард 3-5 удаа лекц, семинар сургалтыг явуулна. | Хамрагдах хүний тоо | 6000-аас доошгүй иргэд | 2.0 /хэлтсийн төсөв/ | **СО ТГХШХ** |
| 4-13 | | "Хотын соёл-Хоггүй дүүрэг" аяныг иргэд хүүхэд залуучуудын дунд өрнүүлнэ. | Зохион байгуулах үйл ажиллагааны тоо | 4 | 2.5 /хэлтсийн төсөв/ | **НХХ** |
| **17** | **4.4 Биеийн тамир, спортын чиглэлээр** | | | | | |
| 4-14 | 4.4.1 Дүүргийн иргэдийн спортын наадмыг олон төрлөөр жил бүр өргөн хүрээнд зохион байгуулна. | Дүүргийн иргэдийн спортын VII их наадмыг 3 үе шаттайгаар спортын 8 төрлөөр зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | 42.0 /НХХ-н төсөв/ | **БТСХ НХХ** |
| 4-15 | 4.4.2 Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөр үе, залуучуудын шигшээ багийн үйл ажиллагааг өргөжүүлж, дэмжлэг үзүүлнэ. | Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийг спортын 10 төрлөөр байгуулж улс нийслэлийн шигшээ тэмцээнд амжилттай оролцуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | 45.0 /НХХ-н төсөв/ | **БТСХ НХХ** |
| 4-16 | 4.4.3 Өсвөр үе, хүүхэд, залуучуудын бие бялдрыг чийрэгжүүлэх, авьяас, ур чадварыг хөгжүүлэх үйл ажиллагааг багийн спортоор дамжуулан хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, үндэсний болон өвөл, зуны спортын төрлийн уралдаан тэмцээн жил бүр зохион байгуулна. | Дүүргийн Засаг даргын харьяа хэлтэс, албадын болон дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудын дунд ДЗД-ын нэрэмжит спортын 5 төрөлт тэмцээнийг тус тус зохион байгуулна. | Зохион байгуулах тэмцээний тоо | 7-оос доошгүй | 14.5 /НХХ-н төсөв/ | **БТСХ НХХ** |
| 4-17 | | Дүүргийн "Цасны баяр"-ын үйл ажиллагааг зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, | 100% | 3.0 /хэлтсийн төсөв/ | **НХХ** |

| № | Дүүргийн засаг даргын 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | 2018 онд хүрэх түвшин, үр дүн | Шаардлагатай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая.төг/ | Хариуцах хэлтэс, албад |
|---|---|---|---|---|---|---|
| 4-18 | 4.4.4 Усан спорт сургалтын төв нэмж байгуулна. | Шинээр усан спорт сургалтын төв байгуулах шаардлагатай газрын байршлыг тогтоож санхүүгийн эх үүсвэрийг улс, нийслэлийн төсөвт суулгуулах ажлыг зохион байгуулна. | Зураг төсвийн ажлын хэрэгжилт, хувиар | 100% | - | **ТГХШХ ГА** |
| **18** | **4.5 Хүүхэд гэр бүл хөгжлийн чиглэлээр** | | | | | |
| 4-19 | 4.5.1 Хүүхдийн насны онцлогт тохирсон хөгжлийн хөтөлбөрийг үндэсний өв уламжлал, өс заншилтай хослуулан хэрэгжүүлж, эрүүл чийрэг бие бялдартай, боловсролтой, амьдрах ухаантай, эх оронч, иргэнийг төлөвшүүлнэ. | Дүүргийн Засаг даргын нэрэмжит "Хүүхдийн урлагийн Их наадам", шатрын "Их нүүдэл" тэмцээнүүдийг зохион байгуулна. | Зохион байгуулах наадмын тоо | 1 | 10.0 /хэлтсийн төсөв/ | **НХХ** |
| 4-20 | | "Замын хөдөлгөөний цагаан толгой-2018" "Ногоон гэрэл, цагаан шугам-2018" тэмцээнүүдийг зохион байгуулна. | Зохион байгуулах тэмцээний тоо | 1 | 6.0 /хэлтсийн төсөв/ | **НХХ** |
| 4-21 | | Монгол улсын иргэний үнэмлэх гардуулах, андгай өргөх ёслолын үйл ажиллагааг сар бүр зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | 7.2 /хэлтсийн төсөв/ | **НХХ** |
| 4-22 | | Өөрийн мэдлэг авьяас, хичээл зүтгэлээрээ бусдыгаа тэргүүлэн урлаг, спорт, сурлагын болон бусад төрлөөр амжилт гаргасан хүүхдүүдэд урам зориг, эрч хүч өгөх, олон нийтэд алдаршуулах, хүүхэд багачуудад үлгэр дуурайлал үзүүлэх зорилгоор "Дүүргийн шилдэг хүүхэд" "Мэтгэлцээний аварга" шалгаруулах арга хэмжээг зохион байгуулна. | Зохион байгуулах арга хэмжээний тоо | 1 | 10.0 /Хэлтсийн төсөв/ | **НХХ** |
| 4-23 | 4.5.2 Хүүхдийн зуслан, тоглоомын талбай, биеийн тамирын талбай, цэцэрлэгт хүрээлэнгийн тоог нэмэгдүүлж, хүүхдийн эрүүл аюулгүй хөгжлийн орчныг бүрдүүлэх бодлого баримтална. | Дүүрэгт хүүхдийн зуслан байгуулах ажлын судалгаа, байршлыг тогтоож зураг, төсөв хийлгэх ажлыг эхлүүлнэ. | Зураг төсвийн ажлын хэрэгжилт, ажлын явц, хувиар | 100% | 80.0 ДТХО | **ТГХШХ ГА** |
| 4-24 | 4.5.3 Дүүргийн хэмжээнд "Хүүхдийн авьяас төв" тавааc доошгүйг байгуулна. | Монголын Хүүхдийн ордон, Хүүхдийн урлан бүтээх төвийн салбар 4 төрлийн дугуйлангуудыг 7, 8, 9 дүгээр хороодод нээн ажиллуулна. | Хэрэгжилтийн явц, хувиар | 100% | 1.0 /ГБХЗХХ-ийн төсөв/ | **ГБХЗХХ** |
| 4-25 | 4.5.4 Хүүхэд хамгааллын үйлчилгээний мэдээлэл хяналтын тогтолцоог бэхжүүлж, Хүүхдийн асрамж, халамжийн төвүүдэд гэр бүлийн хувилбарт үйлчилгээг нэвтрүүлэх замаар хараа хяналтгүй, хөдөлмөр эрхэлдэг, хүчирхийлэлд өртсөн, эрх нь зөрчигдсөн хүүхдийн тоог бууруулна. | Эрсдэлийн түвшин тогтоох програмд хараа хяналтгүй, хөдөлмөр эрхэлэгч, хүчирхийлэлд өртсөн хүүхдийн мэдээллийг оруулж, хүүхэд хамгааллын үйлчилгээ, хяналтыг сайжруулж эрх нь зөрчигдсөн хүүхдийн тоог бууруулна. | Хэрэгжилтийн явц, хувиар | 100% | - | **ГБХЗХХ** |
| 4-26 | | Гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдэд чиглэсэн "Гэртээ харих зам" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | Орон гэргүй иргэдийн тоо буурсан хувиар | 5% | 3.0 /хэлтсийнн төсөв/ | **ХөХҮХ НХХ** |
| 4-27 | 4.5.5 "Гэр бүлийн өдөр"-ийг тэмдэглэхийг хэвшүүлж, гэр бүлийн халуун дулаан уур амьсгалыг бий болгож, тогтвортой харилцааг төлөвшүүлнэ. | Гэр бүлийн өдрийг дүүргийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөө гарган зохион байгуулна. Дүүргийн ёслол хүндэтгэлийн өргөө шинээр байгуулах ажлын тооцоо судалгаа гаргаж ажлыг эхлүүлнэ. | Зохион байгуулах арга хэмжээний тоо | 12 | 5.0 /ГБХЗХХ-н төсөв/ | **ГБХЗХХ** |
| 4-28 | 4.5.6 Хүүхэд, гэр бүлд чиглэсэн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх санал санаачилгыг өрнүүлж, "Хүүхэд, гэр бүлд ээлтэй" байгууллага, үйлчилгээ, орчныг шалгаруулан, олон нийтэд сурталчилна. | Хүүхдэд ээлтэй, гэр бүлийг дэмжсэн үйлчилгээ, санал санаачлагыг өрнүүлж, дүүргийн хэмжээнд хүүхдэд ээлтэй байгууллага хамт олон, үйлчилгээг шинээр нэвтрүүлнэ. | Шинээр нэвтрүүлсэн үйл ажиллагааны тоо | 2-оос доошгүй | 5.0 /хэлтсийн төсөв/ | **НХХ ГБХЗХХ** |

| № | Дүүргийн засаг даргын 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | 2018 онд хүрэх түвшин, үр дүн | Шаардлагатай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая.төг/ | Хариуцах хэлтэс, албад |
|---|---|---|---|---|---|---|
| 4-29 | 4.5.7 Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, үүнээс татгалзах хандлагыг олон нийтэд төлөвшүүлэх сурталчилгаа нөлөөллийн ажлуудыг эрчимжүүлнэ. | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль, Жендэрийн тухай хуулийг гэр бүл,олон нийтэд танилцуулах, хүчирхийллээс өөрийгөө болон бусдыг хэрхэн хамгаалах талаар мэдлэг мэдээлэл өгөх,хүчирхийлэл үйлдэгч гэр бүлийн гишүүдийн зан үйлийг засах,гэр бүлийн боловсрол олгох сургалт зохион байгуулна. | Сургалтын тоо | 4 | 7.0 /хэлтсийн төсөв/ | **НХХ** |
| 19 | **4.6 Залуучуудын хөгжлийн чиглэлээр** | | | | | |
| 4-30 | 4.6.2 Оюутан залуучуудыг нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулж, тогтвортой ажлын байраар хангах, нарийн мэргэжил эзэмшүүлэх цогц арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран үе шаттай зохион байгуулна. | Бизнес эрхлэх хүсэлтэй залуусын бизнес санааг дэмжихэд чиглэсэн "СТАРТ АП" хөтөлбөрийг хэрэгжүүлэн "Залуучуудын хөгжил" онол практикийн бага хурал зохион байгуулна. | Шинээр бий болгох ажлын байрны тоо | 10-аас доошгүй | ХЭДС | **ХөХҮХ** |
| 4-31 | 4.6.3 Залуу эцэг эхчүүдэд зориулсан амьдрах ухаанд сургах, зөвлөгөө мэдээллээр хангах, гэр бүлтэйгээ чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх зориулалт бүхий төвийг нээн ажиллуулна. | Залуу гэр бүлд зориулсан сургалт, зөвлөгөө өгөх төвийг ажиллуулахад шаардлагатай байршлын судалгааг гаргаж зураг төсөв хийлгэх саналыг нийслэлд уламжилна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | - | **НХХ ГБХЗХХ** |
| 4-32 | 4.6.4 Залуусын дунд мансууруулах бодисын хорт нөлөөг таниулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, сургалт сурталчилгааны арга хэмжээг цагдаагийн байгууллагуудтай хамтарч байнга зохион байгуулна. | Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд нийгэм, хамт олонд мансууруулах бодисын хор нөлөөг сурталчилах ажлыг цагдаагийн байгууллагатай хамтран ЕБС-үүдын дунд зохион байгуулж ажлыг эрчимжүүлнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | - | **ЭМТ ЦАГДАА 1,2** |
| 4-33 | | Нийслэл, дүүргийн Эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхүүдтэй хамтран ЕБС-ын сурагчдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор шүүх хуралдаанд оруулж шүүн таслах ажиллагааг танилцуулна. | Арга хэмжээний тоо | 9 | - | **ХЗТасаг** |
| 20 | **4.7 Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр** | | | | | |
| 4-34 | 4.7.1 Өрх бүрийг судалгаанд хамруулж, ажилгүй иргэдийн мэдээллийн баазыг бий болгож, ажилгүй иргэд дүүргийн зохих албад, нэгжүүдтэй харилцах онлайн буюу шууд харилцаа үүсгэх техникийн боломжийг бүрдүүлнэ. Дүүргийн хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн бирж, төрийн болон төрийн бус байгууллагууд, ажил олгогчдын хамтын ажиллагааны нэгдсэн системийг бий болгоно. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрийг дүүргийн хэмжээнд хэрэгжүүлэн хамтын ажиллагааны нэгдсэн системийг бий болгоход чиглэсэн семинар зохион байгуулна. | Зохион байгуулах семинарын тоо | 1 | 3.0 /ХөХҮХ-н төсөв/ | **ХөХҮХ** |
| 4-35 | | Ажил олгогч, аж ахуйн нэгж байгууллагуудаас эрэлт нийлүүлэлтийн судалгаа авах, сул чөлөөтэй ажлын байрны захиалга авч, ажилгүй иргэдийг ажлын байранд зуучилна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | ХЭДС | **ХөХҮХ** |
| 4-36 | 4.7.2 Жижиг дунд бизнес, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдэд таатай нөхцлөөр олгох "итгэлийн зээл" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | Зээлийн баталгаа гаргаж дэмжлэг үзүүлнэ. | Шинээр нэмэгдэж ажлын байртай болсон иргэдийн тоо | 160 | /Батлан даалтын сан/ | **ХөХҮХ ЖДҮДТ** |
| 21 | **4.8 Нийгмийн халамжийн чиглэлээр** | | | | | |

| № | Дүүргийн засаг даргын 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | 2018 онд хүрэх түвшин, үр дүн | Шаардлагатай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая.төг/ | Хариуцах хэлтэс, албад |
|---|---|---|---|---|---|---|
| 4-37 | 4.8.1 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд оролцох боломжийг бүрдүүлэхэд барилга байгууламж, зам талбайн орчинд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэд бүтцийн стандартыг хангуулна. | Дүүргийн төрийн болон үйлчилгээний байгууллагуудад ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй үйлчилгээ, жишиг болохуйц тохижилттой болгох ажлыг шат дараатайгаар зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | - | ТГХШХ |
| 4-38 | 4.8.2 Төрийн үйлчилгээний болон төсөлт ажлуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангаж ажиллана. | Дүүргийн "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний зөвлөл"-ийн үйл ажиллагааг идэвхижүүлэх, ХБИ-дийн эрхийг хамгаалах ОУ-ын өдрийг угтан зөвлөгөөн, өдөрлөг зохион байгуулна. | Зохион байгуулах зөвлөгөөн, өдөрлөгийн тоо | 2 | 5.0 /хэлтсийн төсөв/ | НХХ |
| 4-39 | | Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэдийн үүсэл санаачлагын бүлгийг дэмжих төслүүдийг шат дамжлагатайгаар шалган хороодын Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн санхүүжилж, үйл ажиллагааг дэмжиж ажиллана. | Дэмжлэг үзүүлсэн бүлгийн тоо | 16-аас доошгүй | Нийгмийн халамжийн сан | ХөХҮХ |
| **22** | **4.9 Ахмад настанд үзүүлэх үйлчилгээний чиглэлээр** | | | | | |
| 4-40 | 4.9.1 Ахмадын сувилал, асрамжийн газруудыг шинээр байгуулна. | Ахмадын сувилал байгуулах ажлын судалгаа хийж, зураг төсөв хийлгэх ажлыг эхлүүлнэ. | Зураг төсвийн ажлын хэрэгжилт, хувиар | 100% | | ТГХШХ<br>ГА |
| 4-41 | 4.9.2 Ахмадуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулах ажлыг зохион байгуулна. | Дүүргийн хэмжээнд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах шаардлагатай ахмадын тоог гаргаж үе шаттайгаар эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулах ажлыг Эрүүл мэндийн төв, ӨЭМТ-үүдтэй хамтран зохион байгуулна. | Хамрагдалтын хувиар | 100% | 2.0 /хэлтсийн төсөв/ | НХХ |
| 4-42 | 4.9.5 Ахмадуудыг нийгмийн амьдралд оролцох, өөрсдийн мэдлэг туршлагаа залуу үетэйгээ хуваалцах боломжийг хангах үүднээс "Ахмад үеэсээ суралцъя" төсөлт арга хэмжээг зохион байгуулна. | Сар шинийн баяр, ахмадын баярыг тохиолдуулан дүүргийн ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэн дүүргийн "Өргөмжит ээж" шалгаруулах арга хэмжээг зохион байгуулна. | Ахмад настны хамрагдалт, хувиар | 100 | 61.0 /хэлтсийн төсөв/ | НХХ |
| 4-43 | | Ахмадын бүлэг үүсгэн, бүлгийн үйл ажиллагааг дэмжин, ахмадын зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | Ахмадын бүлгийн тоо | 16-аас дээш | 20.0 /хэлтсийн төсөв/ | НХХ |
| | **ТАВ. ХҮНИЙ ХӨГЖИЛ-ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ** | | | | | |
| **23** | **5.1 Оновчтой бүтэц, уялдаатай үйлчилгээний чиглэлээр** | | | | | |
| 5-1 | 5.1.1 Засаг захиргааны анхан шатны нэгж-хорооны төсөв санхүү, үйл ажиллагааны чадавхийг нэмэгдүүлнэ. Дүүргийн зарим чиг үүргийг хороодод үе шаттайгаар шилжүүлнэ. | Дүүргийн зарим чиг үүргийг хороодод шилжүүлэх ажлын жагсаалтыг гарган, холбогдох дээд шатны байгууллагад уламжилж, хамтран шийдвэрлэнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | - | ТЗУХ |
| 5-2 | 5.1.3 "Авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөр" хэрэгжүүлж, авлигаас ангид төрийн албыг бэхжүүлсэн тунгалаг дүүрэг болно. | Дүүргийн Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулна. | Төлөвлөгөөний тоо | 1 | - | ТЗУХ |

| № | Дүүргийн засаг даргын 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | 2018 онд хүрэх түвшин, үр дүн | Шаардлагатай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая.төг/ | Хариуцах хэлтэс, албад |
|---|---|---|---|---|---|---|
| 5-3 | 5.1.4 "Төрийн албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэх, нийгмийн баталгааг нь хангах хөтөлбөр" боловсруулж, хэрэгжүүлнэ. | "Төрийн албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэх" хөтөлбөрийн хүрээнд Тамгын газрын албан хаагчдыг дотоод, гадаадын дунд болон богино хугацааны сургалт, семинарт хамруулна. | Хамрагдах албан хаагчийн тоо | 10-аас доошгүй | 50.0 /1 удаагийн тэтгэмжийн зардлаас/ | ТЗУХ |
| 5-4 | | "Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг нь хангах" хөтөлбөрийн хүрээндТамгын газрын албан хаагчдын орон байрны нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. | Хамрагдах албан хаагчийн тоо | 10-аас доошгүй | 150.0 /1 удаагийн тэтгэмжийн зардлаас/ | ТЗУХ |
| **24** | **5.2 Ухаалаг төрийн үйлчилгээний чиглэлээр** | | | | | |
| 5-5 | 5.2.1 Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт үе шаттайгаар шилжүүлж, хорооноос үзүүлэх төрийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ. | Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх зорилгоор програм хийлгэх ажлыг эхлүүлнэ. Мэдээллийн аюулгүй байдал нууцлалыг хангах, хяналт тавих ажлын хүрээнд сүлжээний хамгаалалтын төхөөрөмж, Сүлжээний өгөгдөл хадгалах сервер суурилуулна. | Суурьлуулалтын ажлын явц, хувиар | 100% | 70.0 /хэлтсийн төсөв/ | ТЗУХ |
| **25** | **5.3 Ил тод байдлыг сайжруулах чиглэлээр** | | | | | |
| 5-6 | 5.3.1 Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, иргэдийн мэдээллийн санг үүсгэж хувийн хэвшлийнхэнд хүнд суртал, чирэгдэлгүй үйлчлэх системийг бий болгон үр дүнг тооцох, хяналт тавих нээлттэй засаглалын бодлогыг хэрэгжүүлнэ. | Дүүргийн нэгдсэн мэдээллийн цахим сангийн програмыг хөгжүүлэн үйл ажиллагаар эгшрүүлнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | - | СТСХ |
| | | Иргэдэд мэдээлэл өгөх 7777-1965 тусгай дугаарын үйл ажиллагааг тогтмолжуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | - | ТЗУХ |
| 5-7 | 5.3.4 Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдүүлж хэвшүүлнэ. | Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдүүлж ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | - | СТСХ |
| 5-8 | 5.3.5 Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод хяналтыг сайжруулах замаар ажлын байрны эмх цэгц, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх тогтолцоонд бүрэн шилжүүлнэ. | ЗДТГ-ын дотоод хяналтыг сайжруулах тусгай журам боловсруулан батлуулж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. | Журмын тоо | 1 | - | ТГХШХ |
| 5-9 | 5.3.6 Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах үйл ажиллагааны сонгон шалгаруулалтыг ил тод болгож, иргэд, олон нийтийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлнэ. | Аж ахуй нэгж компани болон иргэдэд хуулийн шинэчлэлт болон цахим худалдан авах ажиллагаа, худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох АЗ-ын сургалт зохион байгуулна. | Сургалтын тоо | 2 | 4.2 /ХААА-ны төсөв/ | ХААА |
| 5-10 | 5.3.7 Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох зэрэг газартай холбоотой мэдээ мэдээллийг нээлттэйгээр иргэдэд мэдээлэж ажиллана. | gazar.ub.gov.mn сайтаар иргэдэд газар эзэмших, ашиглах болон бусад холбоотой мэдээллийг нээлттэй ил тод байдлаар хүргэж ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | - | ГА |
| **26** | **5.4 Тогтвортой бодлого хамтын ажиллагааны чиглэлээр** | | | | | |

| № | Дүүргийн засаг даргын 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | 2018 онд хүрэх түвшин, үр дүн | Шаардлагатай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая.төг/ | Хариуцах хэлтэс, албад |
|---|---|---|---|---|---|---|
| 5-11 | 5.4.1 Иргэн-цэргийн харилцааг орон нутагт бэхжүүлэн, батлан хамгаалах салбарын бодлого, үйл ажиллагааг дэмжиж ажиллана. | Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 97 жил, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан Зэвсэгт хүчний цэргийн анги байгууллагуудын үйл ажиллагааг иргэд, ААН-д сурталчлах зорилгоор "**Иргэн–цэргийн бахархлын өдөр**", Засаг даргын нэрэмжит цэрэг спортын "Дөп тоглолт"-ыг зохион байгуулна. | Хамрагдалтын хувь | 93% | 9.2 /хэлтсийн төсөв/ | ЦШ |
| 5-12 | | 2018 оны ээлжит цэрэг татлага, халалтын ажил, Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг шинээр болон давтан сургах ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | 35.6 /хэлтсийн төсөв/ | |
| 5-13 | | "Оюутан-цэрэг" цэргийн мэргэжил олгох сургалтад дэмжлэг үзүүлэн цэргийн насны иргэний эрүүл мэндийн байдлыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах, цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн программыг хөгжүүлнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | 8.7 /хэлтсийн төсөв/ | |
| 5-14 | 5.4.2 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулж, цагийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, хамтран ажиллах замаар "Олон нийтийн цагдаа", "Оюутан цагдаа" арга хэмжээг үргэлжлүүлнэ. | Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийг татан оролцуулж хороо тус бүрт урамшуулалт эргүүлийг байгууллага аж ахуйн нэгжтэй хамтран ажиллуулж гэмт хэрэг, зөрчлийн тоог багасгана. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | - | ЦАГДАА 1,2 |
| 5-15 | 5.4.3 Гэр хороололлыг камерын системд бүрэн хамруулна. | Гэр хорооололд гэмт хэрэг хамгийн ихээр гардаг цэгүүдэд хэсэгчилсэн камер суурилуулах ажлыг Цагдаагийн 2 дугаар хэлтэстэй хамтран үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | Ажлын явц, хувиар | 100% | 354.0 УТХО | ТГХШХ ЦАГДАА 2 |
| 5-16 | | Орон сууцны хороолол дунд СӨХ, ААНБ-ын оролцоонд тулгуурлан үе шаттайгаар камержуулалтыг сайжруулна. | Ажлын явц, хувиар | 100% | - | ТНААХ ЦАГДАА 1 |
| 5-17 | 5.4.4 Сургууль цэцэрлэг, хүүхдийн тоглоомын талбайн камержуулалтыг сайжруулна. | Камержуулах шаардлагатай сургууль, цэцэрлэг, хүүхдийн тоглоомын талбайн судалгаанд үндэслэн камержуулах ажлыг иргэн, аж ахуйн нэгжийн дэмжлэгтэйгээр хэсэгчилэн эхлүүлнэ. | Ашиглалтад орсон камерын тоо, ширхэг | 13 | - | ТГХШХ |
| 5-18 | 5.4.5 Төрийн үйлчилгээний нэг цэгийн төвийг дүүрэгтээ шинээр байгуулна. | Төвийн болон Яармаг, Нисэхийн чиглэлд хороо харгалзахгүй үйлчилгээ авах 1 цэгийн үйлчилгээний төвийг ажиллуулж эхэлнэ. | Ажлын хэрэгжилт, хувиар | 100% | - | ТГХШХ ГА |
| 5-19 | 5.4.6 Иргэдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүднээс цагдаагийн хэсгүүдийг хороодын дунд нэмж байршуулна. | Гэмт хэрэг ихээр бүртгэгддэг хороодын нутаг дэвсгэрт байршлын судалгаанд үндэслэж цагдаагийн кабон барих ажлыг дээд шатны байгууллагуудад уламжилна. | Ажлын хэрэгжилт, хувиар | 100% | - | Цагдаа 1,2 ТГХШХ ГА |